

БИДИСЕК ҮЦК ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 3 сарын 15 -ны өдөр

№

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар санал хурааж, олонхийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “БиДиСек ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 4 сарын 26 -ны өдөр 10 цагт Улаанбаатар хотод “БиДиСек ҮЦК” ХК-ийн өөрийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - а) Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
 - б) Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
 - в) Компани ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-н гаргасан шийдвэрийг танилцуулах
 - д) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - е) ТУЗ-ийн 2017 оны төсөв батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 4 дугаар сарын 5 - ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2017 оны 3 дугаар сарын 20 - ны өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани хөрөнгийн биржийн цахим

хуудсаар мэдээллэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 4 дүгээр сарын 4 –ний өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2017 оны 3 дугаар сарын 25 - ны өдрөөс хойш 09⁰⁰-18⁰⁰ цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харъяалагдах брокер, дилерийн компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 1 хоногийн өмнө байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар О.Уранбайгаль гишүүнээр Ө.Даваасүрэн нарыг тус тус томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Компанийн Тэргүүн Дэд захирал Б.Лхагвадорж, тооллогын комиссын даргаар Г.Гэрэлт-од гишүүдээр “БиДиСек ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн Д.Шүрэнцэцэг нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/